



**НИЙСЛЭЛИЙН  
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ  
ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР**

2015 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 15/15

Улаанбаатар хот

Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр  
гүйцэтгэгч нарт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.4,1 дэх заалт, Шийдвэр гүйцэтгэх газрын дарга, улсын ерөнхий гүйцэтгэгчийн 2015 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн албаны хамт олны хурал дээр өгсөн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ДААЛГАХ НЬ:

Шийдвэр гүйцэтгэх газрын дарга болон мэргэжлийн удирдлагын хэлтсийн даргын 2015 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн албаны хурал дээр өгсөн үүргийг нэг бүрчлэн хэрэгжүүлж ажиллахыг нийт шийдвэр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай. Үүнд:

1.1 Иргэн, аж ахуйн нэгж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудтай үйлчилгээний стандартыг баримтлан зөв боловсон хүндэтгэлтэй харилцаж, эрх үүргийг танилцуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар мэдээлэл өгч, тэмдэглэл хөтөлж хэвших.

1.2 Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хийх явцдаа бусдын нөлөөнд автахгүй, авлигын асуудалд орохгүй байж шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуулийн дагуу зөв, шуурхай явуулах.

1.3 Албаны хэмжээн дэх гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийн нэгдүгээр улирлын мэдээг цахим хэлбэрээр авах болсонтой холбогдуулан албанд шинээр болон харьяаллын дагуу шилжин ирсэн түүнчлэн гар дээр байгаа гүйцэтгэх баримт бичиг нэг бүрийг цахим бүртгэлд стандартын дагуу бүрэн, үнэн зөв, алдаагүй бүртгэж оруулах ажлыг зохион байгуулж бүртгэлд оруулаагүй гүйцэтгэх хуудасгүй болсон байх.

1.4 “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох” журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор хохирогч буюу түүний хууль ёсны төлөөлөгч нөхөн төлбөр хүсэх өргөдлөө гаргана” гэж заасны дагуу албанд ирсэн эрүүгийн хэргийн гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авсан даруйд журамд хамрагдах эсэхийг судалж, хамрагдах тохиолдолд тухайн төлбөр авагчид мэдэгдэн өргөдөл болон түүнд хавсаргах баримт бичгийг бүрдүүлэн Шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлэх.

1.5 “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох” журмын 7 дугаар зүйлд зааснаар төлбөр авагчид олгосон нөхөн төлбөрийн мөнгийг шүүхийн шийтгэх тогтоолын дагуу төлбөр төлөгчөөс цаг алдалгүй эргэн төвлөрүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах.

1.6 Гүйцэтгэх баримт бичигт хуульд заасан бүхий л ажиллагааг бүрэн явуулж баяжилт хийсний эцэст харьяаллын дагуу шилжүүлэх ажлыг зохион байгуулах.

1.7 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь хэсэгт зааснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд эвлэрч гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож байгаа тохиолдолд энэ үндэслэлээр гомдол гаргах эрхгүй болохыг танилцуулж, тэмдэглэл хөтлөн баталгаажуулж гүйцэтгэх баримт бичигт хавсаргах.

1.8 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан үндэслэлээр гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцааж, буцаасан гүйцэтгэх баримт бичгийг цахим бүртгэлийн мэдээллийн санд бүртгэн архивт шилжүүлэх.

2.Нийт шийдвэр гүйцэтгэгч нарт өгсөн үүргийн хэрэгжүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангаж, зөвтгөн ажиллахыг ахлах шийдвэр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү албан даалгаврын дагуу ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтэд хяналт тавьж 2015 оны 01 дүгээр сарын 23-ны дотор илтгэх хуудсаар танилцуулахыг дэд дарга /дэд хурандаа Ч.Оюунцэцэг, хошууч Ж.Нандинтуул/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ХУРАНДАА



Э.БАТБАЯР